“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ”ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2011 оны 03 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 36 | Багануур

Журам батлах тухай

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн гишүүдийн 2011 оны 02 сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

Нэг. “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн “Автомашин, механизмаар төлбертэй үйлчлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Авто машин механизмаар үйлчлэх гэрээний маягтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Гурав. “БНДС” ТӨХК-ийн “Авто машин, механизмаар төлбертэй үйлчлэх үнэ тарифыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Дөрөв. Энэ журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг автын механик /А.Баярмагнай/, Санхүү борлуулалтын хэлтсийн дарга /Ц.Энхцэцэг/ нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

62

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын

2011 оны 03-р сарын 02-ны өдрийн 36 тоот тушаалын 1-р хавсралт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн автомашин механизмаар төлбөртэй үйлчлэх журам

Нэг. Зорилго

Гадны байгууллага болон байгууллагын ажиллагсад, өндөр настан, МШӨ-ний улмаас группэд гарсан хүмүүст хувийн зайлшгүй хэрэгцээ гарсан тохиолдолд тээврийн хэрэгслээр хөнгөн шуурхай үйлчлэх бөгөөд захиалсан хугацаандаа ажлаа гүйцэтгэж , компанийн ажлыг саатуулахгүй байхад оршино.

Хоёр. Үйлчлэх хүрээ

Автомашин механизмыг боломжтой тохиолдолд гадны байгууллага болон ажиллагсдад ҮО, МШӨ-ний группэй, өндөр настан хүмүүст түр хугацаагаар хувийн хэрэгцээнд нь ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр томилж болно.

Гурав. Автомашин, механизмыг хувийн хэрэгцээнд ажиллуулах

3.1 Төлбөртэй ажил үйлчилгээг захиалагч буюу хэрэглэгчийн бичгээр гаргасан албан ёсны хүсэлт, захиалгыг үндэслэн компанийн гүйцэтгэх захирал, СБХ-ийн даргын зөвшөөрлөөр, гэрээ байгуулсны үндсэн дээр автомашин механизмаар үйлчилгээ үзүүлэх.

3.2 Захиалагч байгууллага, хүмүүс нь хэдий хугацаанд хичнээн км-т ямар автомашин, механизмаар үйлчлүүлэх талаар хүсэлтээ тодорхой бичсэн байна.

3.3 Автомашин механизмаар үйлчлэх тарифыг баримтлан бэлэн бусаар төлбөр хийх байгууллага, хүмүүст төлбөрийн нэхэмжлэл, бэлнээр төлбөр хийх нөхцөлд бэлэн мөнгөний орлогын баримт бичиж байх.

3.4 Автын механик автомашин механизмын бүрэн бүтэн байдал, жолоочийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын талаар үйлчилгээний бүх чанарыг ханган үйлчилгээнд гаргана.

3.5 Хавсралт №1/Автомашин механизмаар үйлчлэх гэрээ/-р гэрээ байгуулах.

3.6 Хавсралт №2/Автомашин механизмаар үйлчлэх тариф/-р төлбөр тооцоо хийх.

3.7 Гэрээ байгуулан, төлбөрийн тооцоог хийснээр автомашин механизмаар үйлчлүүлнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо.

4.1 Үйлчлүүлэгч батлагдсан тарифын дагуу тооцоог хийнэ.

4.2. Төлбөрийг бэлэн ба бэлэн бусаар хийж болно.

4.3 Тооцооноос илүү км.цаг явсан бол үйцэтгэлийн дагуу зөрүү төлбөрийг үйлчлүүлэгч нэмж төлнө.

63

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын

2011 оны 03-р сарын 02-ны өдрийн 36 тоот тушаалын 1-р хавсралт

Автомашин механизмаар үйлчлэх гэрээ

Багануур дүүрэг ...оны ...сарын ..-ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас "Багануурын дулааны станц" ТӨХК-ийг /цаашид үйлчлэгч гэх/төлөөлж автын механик А.Баярмагнай, нөгөө талаас /цаашид үйлчлүүлэгч гэх/ Багануур дүүргийн..-р хороо, ...байр, гудамж, ...тоотод оршин суугч .....регистрийн дугаартай иргэн .....нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1 Гадны байгууллага болон байгууллагын ажиллагсад, өндөр настан, ҮО, МШӨ-ний улмаас группэд байгаа хүмүүст хувийн хэрэгцээнд автомашин механизмаар үйлчлүүлэх зайлшгүй хэрэгцээ гарсан тохиолдолд бүрэн бүтэн тээврийн хэрэгслээр хөнгөн шуурхай үйлчлэх бөгөөд захиалсан хугацаандаа ажлаа гүйцэтгэж , компанийн ажлыг саатуулахгүй байхад оршино.

Хоёр. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

2.1 Автомашин механизмаар үйлчлүүлэгч нь компанийн захиргаанд хүсэлт захиалгаа албан бичиг, өргөдлөө гарган шийдвэрлүүлсний үндсэн дээр автомашин механизмаар үйлчлүүлэх.

2.2 Албан бичиг,өргөдөлд заасан хугацаа, явах газар, /км/цаг/, үйлчлүүлэх хүрээнээс өөр ажил үйлчилгээнд ашиглахгүй байх.

2.3 Үйлчлүүлэгч нь автомашин механизмын явсан км, хийсэн ажлын гүйцэтгэлийг замын хуудас, дагалдахад бичилт хийх ба жолоочийн томилолтыг хаан гарын үсэг зурна.

2.4 Автомашин механизмыг авч ажиллуулж байх хугацаанд эвдлэх, бүрэн бус техниктэй явж зөрчил гаргавал буруутай этгээд хариуцлага хүлээнэ.

2.5 Хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгэлээр зөрүү тооцоог хийх,түүнээс гарах хохирлын хариуцлагыг бүрэн хариуцна.

2.6 Ажил үйлчилгээ дууссаны дараа автомашин механизмыг хариуцсан албан тушаалтанд өөрийн биеэр ирж хүлээлгэж өгнө.

64

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын

2011 оны 03-р сарын 02-ны өдрийн 36 тоот тушаалын 3-р хавсралт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн автомашин механизмаар үйлчлэх үнэ тариф

№	Автомашины нэр	Зориулалт	Ажилбар	Хэмжих нэгж	Тариф/төгрөг/НӨАТ-гүй			
					1 км-т		1 цагт	
					шатахуунтай	Шатахуунгүй	шатахуунтай	Шатахуунгүй
1	УАЗ-3771 Пургон	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	525	300	42000	24000
2	Грейс микро	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	360	200	28400	15600
3	Чейзерь	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	360	200	36200	19800
4	Пажеро	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	450	250	45000	24300
5	Ланд-80	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	610	340	61000	33600
6	Автобус	Суудлын	Гүйлтийн үнэ	1 км-т	1100	580	53600	29000
7	Самосвал Зил-555	Ачиж буулгах	Гүйлтийн үнэ	1 км-т	900	410	45000	20300
			Механизм ажиллуулах	1тн/км	1100	610	65000	40300
8	Исузу	Өргөх буулгах	Гүйлтийн үнэ	1 км-т	460	240	22900	12000
			Механизм ажиллуулах	М.цаг			30000	22000
9	Бульдозер	Түрэх	Механизм ажиллуулах	М.цаг			80000	60000
10	Сак	Гагнах	Механизм ажиллуулах	М.цаг			17400	9900

Тайлбар: 1. Шатахууны үнэ нэмэгдэхэд нэмэгдсэн хувь хэмжээгээр өөрчлөгдөж тооцогдоно.

2.Тээврийн хэрэгслийг хөлслүүлэх, хөлслөх гэрээг 2 тал харилцан байгуулж, тусгай журмаар зохицуулна.

3.Өөрийн ажиллагсдад үйлчилгээний хөлсийг нь 50 хувийн хөнгөлөлттэй олгоно.

4. Ажлын 8 цагаас дээш автомашин, механизмаар үйлчлэхээр бол тухайн үед нь үнийн тарифаа тохиролцоно.

65